

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Долгорын Цэрэндорж	Дугаар	L083
Оршин суугаа аймаг	Хэнтий аймаг	Оршин суугаа сум	Батширээт
Төрсөн газар	Батширээт сум	Төрсөн он	1929
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Ашингийн дуган	Сүм хийдийн дугаар	ХЭБШ 083
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 6	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Хэнтий аймгийн Батширээт сумын Ашингийн дуган

-Ашингийн дуган хэдэн оны үед байсан дуган бэ?

Тэрийг мэдэхгүй юм аа.

-За нэг хоёр л дугана хүрж байсан байхдаа тийм үү? Нэг нь аниа нарын дугана юм уу ?

Тийм.

-Тэр нь одоо дандаа жод хурдаг байсан уу? Улааны шашны ?

Тэгдэг дандаа жодын хуралтай.

-Ашингын дуганыг юу гэж нэрлэдэг байсан юм бол төвдөөр?

Дашравжаалан гэдэг байсан.

-Лам нарын тоо хэр олон лам нар байсан юм бол доо хуучин хүрж байх үед?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Лам нар ч нэлээн байдаг байсан байх, чухам тоо нь хэд байсан юм бол мэдэхгүй.

-Ямар ямар хурлууд хурдаг байсан бол? Онцлог хурлуудын тухай? Майдар эргэж цам гардаг байсан үү? ?

Цам гардаг байсан.Майдар эргэдэг байсан байхаа. Хааяа нэг эргэдэг л байсан байх.

-Ер нь тэгээд бусад газруудад хурдаг ихэнх хурлууд хурдаг байсан байх даа тийм үү?

Бүх хурлууд хурдаг байсан, том л дугана байсан. Том том лам нараас Лувсан, Ням зэрэг хүмүүс байсан.

-Энд чойртой байсан үү?

Чойр хурдаг байсан.

Гэлэгжамц гэдэг байсан. Энд таван ухааны сургалт байгуулсан. Шинжлэх ухааны хүрээнд ажиллаж байсан.

Сүүлд энд ирж сургалт явуулж байсан.

Танай нутагт өөр ямар хурлын газар байсан бэ? Шүтээн довоос өөр.

Улаан бургасанд гэж нэг газар байсан. Сайн мэдэхгүй.

-Одоо туурь гэж мэдэгдэх юм байгаа болов үү?

Мэдэхгүй.